



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ТОГТООЛ

2021 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27¹1.4 дүгээр зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 91 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Улсын онцгой комиссоос ТОГТООХ нь:

1. Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан түр журамд заасан бүх нийтийн бэлэн байдал /Улаан түвшин/-д шилжсэн үед төрийн байгууллага, хуулийн этгээд, хүний үйл ажиллагааны горимыг чанд мөрдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

2. Нийслэлийн хэмжээнд хязгаарлахгүй үйл ажиллагаа явуулах иргэн, аж ахуйн нэгж байгууллагад тодорхой маршрутын дагуу зорчих эрх бүхий QR код олгох замаар хөдөлгөөн зохицуулалтыг өндөр хяналттай зохион байгуулах, холбогдох зохицуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа Ж.Болд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар нарт үүрэг болгосугай.

3. Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт албан байгууллагын өрөө тасалгаа, байр, орон сууцны орц, хонгил, цонх, хаалга, цахилгаан шат, нийтийн тээврийн хэрэгслийн хаалга, суудал, бариул, хүүхдийн тоглоомын талбай зэрэг халдвар тархах эрсдэл бүхий орчныг халдваргүйтгэлийн ажлыг эрчимжүүлэх, цэвэрлэх болон ариутгах татуургаас халдвар тархах эрсдэлийн үнэлгээг хийж, холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Т.Гантулга, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн ерөнхий захирал Н.Цогбадрах, аймаг, нийслэлийн засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Бүх нийтийн бэлэн байдлын үед иргэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ, түлш, зөөврийн ус, хүнс, ахуйн хэрэглээний бараа бүтээгдэхүүн худалдан авах, эмийн сангаар үйлчлүүлэх, шинжилгээ, дархлаажуулалтад хамрагдах зохицуулалтын арга хэмжээ авч, хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн сайд, Цагдаагийн ерөнхий газрын дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Иргэдийн эрүүл мэндийг дэмжих, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилгоор оршин суугаа газрын гадна талбай, цэцэрлэгт хүрээлэн, тоглоомын талбайд алхах, дугуй унах, биеийн тамирын дасгал хөдөлгөөн хийхийг хатуу хязгаарлахгүйгээр хүн хоорондын зайг хатуу барих, нэг дор 3-аас илүү хүн цуглахгүй /гэр бүлийн хүрээнээс бусад/ байх талаар иргэдэд тогтмол мэдээлж, хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн ерөнхий газрын дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

6. Оршуулга, буяны үйл ажиллагаанд оролцсон иргэдээс халдвар тархах эрсдэл өндөр байгаа тул тодорхой хязгаарлалт, хүний тоог зааж зохион байгуулах талаар иргэдэд зөвлөмж, анхааруулга өгч, хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

7. Эрүүл мэндийн байгууллага дархлаажуулалтын төлөвлөгөөний дагуу Нийслэл хотод дархлаажуулалтын суурин 120 цэг, явуулын 40 цэг (автобус)-ээр дархлаажуулах дэд бүтцийг бий болгож, нийслэлийн иргэдийг 2021 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн дотор вакцинд хамруулж дуусгах, орон нутагт эрүүл мэндийн салбар, хариу арга хэмжээний баг, стратегийн ач холбогдол бүхий салбарын ажилтан, албан хаагч, иргэдийг давхар дархлаажуулж, ажиллахыг Эрүүл мэндийн сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

8. Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан халдварын голомт бүхий аймаг, нийслэлд хавьтал тогтоох, тандалт судалгааг эрчимжүүлэх, эрт илрүүлэх, зохион байгуулалтын бүх талын арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирал Л.Баттөр, Шуурхай штабын дарга Ц.Ганзориг нарт үүрэг болгосугай.

9. Эрүүл мэндийн байгууллагуудаар үйлчлүүлэгчдэд PCR шинжилгээ авч, хариуг богино хугацаанд гаргаж шинжилгээнд хамрагдаж буй нийт иргэдийг чирэгдэлгүй үйлчлүүлэх нөхцөл бүрдүүлж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирал Л.Баттөрт үүрэг болгосугай.

10. Улаанбаатар хотод эрчимт эмчилгээнд зориулж орны тоог 100-аар нэмэгдүүлэх, хувийн хэвшлийн эмнэлэг, сувилал тэдгээрийн эмч эмнэлгийн ажилтан

нарыг нэмэлтээр дайчлан ажиллуулахтай холбоотой ажлын хуваарь, төсөв зардал, тооцоо хийж танилцуулахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболдод даалгасугай.

11. Аймаг, орон нутагт шаардлагатай түргэвчилсэн оношлуурын нөөцийг 500 мянгаар, шүлснээс шинжилгээ авах оношлуурын нөөцийг 100 мянгаар тус тус нэмэгдүүлэх, хүчилтөрөгчийн аппарат, зөөврийн баллон, дагалдах хэрэгслийн нөөцийг шаардлагатай хэмжээнд бүрдүүлж, халдварыг оношлох, эмнэлгийн тусламж үйлчилгээг шуурхай зохион байгуулахыг Эрүүл мэндийн сайд, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Халдварт өвчин судлалын төвийн захирал нарт даалгасугай.

12. Халдвар өртөлтийн бүртгэлийн системийг цахимжуулж, эрүүл мэнд, урьдчилан сэргийлэх чиглэлийн зөвлөмж, зөвлөгөө нэгдсэн зохион байгуулалттайгаар иргэдэд цаг алдалгүй хүргэхийг Харилцаа, холбоо мэдээллийн технологийн газар, Улсын онцгой комиссын Шуурхай штабт даалгасугай.

13. Зорилтот бүлгийн өрхөд нэг удаа хүнсний болон 60 ба түүнээс дээш насны ахмадуудад дархлаажуулах багцыг хэрэглэх заавар, зөвлөмжийн хамт 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн дотор олгох, хариу арга хэмжээнд оролцож байгаа эрүүл мэнд, цагдаа, онцгой, тагнуул, мэргэжлийн хяналт, хил гааль, зам тээврийн байгууллагуудын нийт ажилтан, албан хаагч нарт олгох нэмэгдэл цалин, нэг удаагийн урамшууллын зардлын тооцоог гаргаж, Улсын онцгой комисст 4 дүгээр сарын 12-ны дотор танилцуулахыг холбогдох байгууллагын дарга нарт даалгасугай.

14. Уул уурхайн бүтээгдэхүүн, экспорт, импортын ачаа тээвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын хөрөнгө оруулалтаар хилийн боомтуудад олон улсын стандартад нийцсэн халдваргүйжүүлэлтийн цэгийг байгуулж, 2021 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн дотор ашиглалтад оруулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар нарт даалгасугай.

15. БНХАУ-тай хиллэдэг аймаг, сумдын иргэд, уул уурхайн компаниудын ажилчдыг вакцинд хамруулж, уурхайн эзлж солих ажлыг 2021 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл сунгах, орон нутагт халдвар тархахаас сэргийлэх зорилгоор дараагийн эзлжийн ажилтнуудыг дархлаажуулалтад хамрагдсаны дараа солилцуулах арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн сайд, Уул уурхай хүнд үйлдвэрийн сайд, Дорноговь, Өмнөговь аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

16. Орон нутагт уул уурхай, зам, барилга, эрчим хүч, инженерийн байгууламж, газар тариалан эрхэлдэг байгууллага, аж ахуйн нэгжийн ажилтан, алба хаагчдыг нэгдсэн зохион байгуулалтад оруулж, тухайн объект, ажлын байранд халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлж, ажлын тусгай горимоор ажиллуулахыг холбогдох байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагуудад даалгасугай.

17. Улсын онцгой комиссын шуурхай штабын өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглагдах мэдээ, мэдээллийг тогтоосон цагт ирүүлэх, цахим хэрэглээг бүрэн нэвтрүүлэх, мэдээлэл солилцооны шуурхай байдлыг хангах, иргэд, олон нийтийн гомдол мэдээллийг тухай бүрт нь шуурхай шийдвэрлэж ажиллахыг холбогдох байгууллагын удирдлагууд, Улсын онцгой комиссын Шуурхай штабт үүрэг болгосугай.

18. Мэдээлэл лавлагааны "119" нэгдсэн дугаарын мэдээллийн шугам, чанар, хүртээмжийг өргөтгөх, дуудлагын төвийн оператор ажилтнуудын тоог 2 дахин нэмэгдүүлэх, иргэд, олон нийтэд шаардлагатай зөвлөмж, зөвлөгөөг 24 цагаар өгч ажиллахыг Харилцаа, холбоо мэдээллийн технологийн газар, Улсын онцгой комиссын Шуурхай штабт үүрэг болгосугай.

19. Коронавируст халдвар /Ковид-19/-аас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, иргэдэд зөвлөмж, зөвлөгөө өгөх зорилгоор МҮОНРТ-ээр тогтсон цагт өдөр бүр 30 минутаас доошгүй хугацаанд тусгай нэвтрүүлэг, контент бэлтгэж түгээх, цахим эмчилгээний талаар зөвлөгөө, мэдээллээр хангаж ажиллахыг Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз, Засгийн газрын хэвлэл, мэдээллийн газарт, Эрсдэлийн мэдээлэл, харилцааны түр хороонд даалгасугай.

20. *Emongolia* цахим хуудсанд Коронавируст халдвар /Ковид-19/-ын арга хэмжээний талаарх бодлого, шийдвэр, эмчилгээ, оношлогоо, шинжилгээ, дархлаажуулалт зэрэг нийгмийн эрүүл мэндийн талаарх мэдээ, мэдээллийг өдөр бүрийн 10:00 цагт тогтмол байршуулж, яаралтай мэдээг тухай бүр оруулах, иргэд, олон нийтийг мэдээллээр хангаж ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Харилцаа, холбоо мэдээллийн технологийн газрын дарга Б.Болор-Эрдэнэ, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Эрсдлийн мэдээллийн хороо, Засгийн газрын хэвлэл, мэдээллийн газарт үүрэг болгосугай.

21. Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд /Ковид-19/-ын халдвараас урьдчилан сэргийлэх, хамгаалах, тэмцэх чиглэлээр Засгийн газраас гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хянах, батлагдсан тохиолдлын гэрийн эмчилгээ, тусламж үйлчилгээний чанар хүртээмж болон гудамж, зам талбай, байр, орон сууц, орц, объектийн халдваргүйжүүлэлтийн явц байдалд хяналт тавьж ажиллах тус бүр 5-6 хүний бүрэлдэхүүнтэй Ажлын хэсгийг байгуулж, нийслэлийн дүүрэг, хороо, хэсгүүдэд хуваарилж хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга нарт даалгасугай.


22. Дархлаажуулалтад шаардлагатай хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжийг татан авч, бэлтгэх, хадгалах агуулахын асуудлыг 2021 оны 4 дүгээр сард багтаан

шийдвэрлэхийг Эрүүл мэндийн яам, Халдварт өвчин судлалын үндэсний төв, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

23. Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд 18 градусаас дээш агууламжтай согтууруулах ундааны зүйлс, түүгээр үйлчлэхийг хориглох, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ авч, хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн ерөнхий газар, аймаг, нийслэлийн засаг дарга нарт даалгасугай.

Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын онцгой комиссын нарийн бичгийн дарга, хурандаа Ж.Амгалан, Улсын онцгой комиссын Шуурхай штабын дарга, хурандаа Ц.Ганзориг нарт үүрэг болгосугай.

ДАРГА



САМАРСАЙХАН